



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар A/23

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/305 дугаар тушаал, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 3 дугаар бүлгийн 3.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажлыг гүйцэтгэх эрх зүйн орчинг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах, судлаачдын үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУШААХ нь:

1. “Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл, шилдэг судлаач шалгаруулж, урамшуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын дагуу мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн алба (Д.Алтантогтох)-нд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны алба (Э.Номин)-нд даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан төвийн Захирлын 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБЯАР

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ БҮТЭЭЛ, ШИЛДЭГ СУДЛААЧ ШАЛГАРУУЛЖ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Зоонозын өвчин судлалын үндэсний төв, орон нутгийн Зоонозын өвчин судлалын төвүүдийн мэргэжилтнүүдийг эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхэд сэдэл өгөх, идэвхжүүлэх болон эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлсэн, судалгааны ажлын томоохон төсөл, хөтөлбөр санаачилан хэрэгжүүлсэн судлаачийг сонгон шалгаруулж, урамшуулал олгох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Эрдэм шинжилгээний бүтээлийг дараах төрлөөр жил бүр сонгон шалгаруулна. Үүнд:

1.2.1. Эрдэм шинжилгээний өгүүллийн төрөл (цаашид “өгүүлэл” гэх), үүнд мэргэжлийн сэтгүүл болон эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд нийтлүүлсэн өгүүлэл/илтгэл.

1.2.2. Эрдэм шинжилгээний номын төрөл (цаашид “нэг сэдэвт бүтээл” гэх), үүнд ном, нэг сэдэвт бүтээл төрлийн бүтээлүүд, номын 1 буюу түүнээс дээш тооны бүлэг багтана.

1.3. Шилдэг судлаачийг “Шилдэг судлаач”, “Шилдэг залуу судлаач” гэсэн 2 ангиллаар шалгаруулна. Үүнд:

- “Шилдэг судлаач” төрөлд Зоонозын өвчин судлалын үндэсний төв болон орон нутгийн ЗӨСТ-д ажиллаж буй 35-аас дээш насны судлаач.
- “Шилдэг залуу судлаач” төрөлд Үндэсний төв болон орон нутгийн ЗӨСТ-д ажиллаж буй 35 ба түүнээс доош насны судлаач.

Хоёр.Шилдэг бүтээлд тавигдах шаардлага

2.1. Шилдэг бүтээлд нэр дэвшиж буй эрдэм шинжилгээний бүтээл нь өмнөх жилийн сонгон шалгаруулалт явагдсан өдрөөс хойш хугацаанд нийтлэгдсэн байна.

2.2. Шилдэг бүтээлд нэр дэвшиж буй өгүүлэл нь олон улсын хянан магадалгаа бүхий сэтгүүл, үндэсний хэмжээний өндөр чансаатай мэргэжлийн сэтгүүл, олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд нийтлэгдсэн өгүүлэл/илтгэл байна.

2.3. Дотоодын сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл нь Зоонозын өвчнүүдийн чиглэлээр хийгдсэн судалгааны ажлын үр дүнгээр бичигдсэн байна.

2.4. Шилдэг бүтээлд нэр дэвшиж буй бүтээлийн нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогч нь Зоонозын өвчин судлалын үндэсний төв, орон нутгийн Зоонозын өвчин судлалын төвийн үндсэн ажилтан байх.

2.5. Сонгон шалгаруулалтад өрсөлдөж буй ном нь мэргэжлийн түвшинд боловсруулалт хийгдсэн, 30 ба түүнээс дээш хуудастай, ISBN дугаар бүхий (published) бүтээл байна. Магистр болон докторын зэрэг хамгаалсан нэг сэдэвт бүтээлд ISBN хамаарахгүй.

2.6. Дараах бүтээлүүд ном төрөлд өрсөлдөхгүй.

2.6.1. Бусад зохиогчдын бүтээлийг нэгтгэсэн;

2.6.2. Иргэд болон эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад зориулсан бүх төрлийн гарын авлага, ухуулах материал;

2.6.3. Гадны аль нэг хэлнээс шууд орчуулсан цахим материал;

2.6.4. Дахин хэвлэсэн бүтээл

Гурав. Шилдэг судлаачид тавигдах шаардлага

3.1. Тухайн жилд олон улсын хянан магадалгаа бүхий шинжлэх ухааны сэтгүүлд нэгдүгээр юм уу, холбоо барих зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн болон хурлын эмхэтгэлд нэгдүгээр юм уу холбоо барих зохиогчоор өгүүлэл/илтгэл нийтлүүлсэн байх.

3.2. Тухайн жилд дотоодын хянан магадалгаа бүхий шинжлэх ухааны сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн болон үндэсний эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд өгүүлэл, эрдэм шинжилгээний илтгэл хэвлүүлсэн байх.

3.3. Шилдэг судлаач сонгон шалгаруулалтад оролцох судлаач нь өмнөх жилийн сонгон шалгаруулалт явагдсан өдрөөс хойшхи хугацаанд судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэсэн эсвэл гүйцэтгэж байсан судалгаа, шинжилгээний ажлын үр дүн нь гарсан байх ба судалгааны үр дүнгээр хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт, тухайн жилд нийт хэвлүүлсэн өгүүлэл, хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээний илтгэл, нийт судалгааны материалуудын тухайн жилд иш татагдсан байдлын жагсаалтыг гаргасан байна.

3.4. Судалгааны ажил, хэвлүүлсэн бүтээл, хэлэлцүүлсэн илтгэлүүд нь зоонозын өвчин судлалын чиглэлийн байх.

3.5. Судлаач нь Google Scholar (www.scholar.google.com) болон ORCID (www.orcid.org)-д бүртгэлтэй байх.

Дөрөв. Сонгон шалгаруулалт

4.1. Энэ журмын 1.2.1-д заасан шилдэг өгүүллийг шалгаруулахдаа мэдээллийн сангаас гаргадаг эшлэл, үр дүнгийн тайланд суурилж шалгаруулна.

4.2. Энэ журмын 1.2.2-т заасан төрөлд нэр дэвших нэг сэдэвт бүтээлийг дараах баримт бичгийн хамт, тус төвийн Эрдэм шинжилгээний асуудал эрхэлсэн нэгжид жил

бүрийн 11 дүгээр сарын 2 дахь долоо хоногийн баасан гарагийн дотор бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:

4.2.1. Энэ журмын 1 дүгээр хавсралтаар баталсан нэр дэвшүүлэх маягт

4.2.2. Номын танилцуулга болон түүний редактор, зохиогч (ид) тус бүрийн товч танилцуулга (А4 хуудасны нэг нүүрэнд багтаана).

4.2.3. Зохиогчийн эрх эзэмшигчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлэхийг дэмжсэн зөвшөөрөл.

4.2.4. Судалгааны төслийн хүрээнд хэвлэгдсэн нэг сэдэвт бүтээлийн хувьд төслийн талаарх товч мэдээлэл.

4.2.5. Нэр дэвшиж буй номын хэвлэмэл хувь.

4.3. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирлын шийдвэрээр шилдэг өгүүлэл, шилдэг ном, шилдэг судлаач сонгон шалгаруулалтыг эрдэм шинжилгээний асуудал эрхэлсэн нэгж тухайн оны 11 дүгээр сарын 3 дахь долоо хоногийн баасан гарагаас өмнө зохион байгуулж, Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрийг гаргуулна.

4.4. Энэхүү журмын шаардлагыг хангаж буй өгүүллийг Хавсралт 2-т заасан үнэлгээний хуудсаар үнэлнэ. Үүнд:

4.4.1. Хэвлэгдсэн сэтгүүлийн тухайн жилийн, эсвэл өмнөх жилийн Impact Factor үзүүлэлт.

4.4.2. Эрдэм шинжилгээний өгүүллийн нөлөөлөл.

4.4.3. Зохиогчийн бүтээмжийн үзүүлэлт (*нэгдүгээр зохиогч, хамтран зохиогч зэрэг үзүүлэлт*).

4.5. Энэхүү журмын шаардлагыг хангаж буй нэг сэдэвт бүтээлийг Хавсралт 3-т заасан үнэлгээний хуудсаар үнэлнэ. Үүнд:

4.5.1. Нэг сэдэвт бүтээлийн бичилт, зохион байгуулалт, агуулгын чанар

4.5.2. Нэг сэдэвт бүтээлийн зоонозын өвчний шинжлэх ухааны салбарт оруулж буй хувь нэмэр, ач холбогдол

4.5.3. Сэдвийн судлагдсан байдал

4.5.4. Шинэлэг байдал болон ашиглагдаж буй нотолгоо, жишээний оновчтой байдал

4.5.5. Нэг сэдэвт бүтээлийн дүгнэлт, утга санааны ойлгомжтой байдал

4.5.6. Нэг сэдэвт бүтээлийн өгүүлбэр зүй, бичилт

4.5.7. Нэг сэдэвт бүтээлийн үзэмж, хэвлэлийн чанар, дизайн.

4.6. Энэхүү журмын шаардлагыг хангаж буй шилдэг судлаачийг дараах үзүүлэлтээр буюу Хавсралт 4-т заасан үнэлгээний хуудсаар үнэлнэ. Үүнд:

4.6.1. Олон улсын хянан магадалгаа бүхий сэтгүүл, хурлын эмхэтгэлд нийтлүүлсэн өгүүллийн тоо.

4.6.2. Олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлийн тоо, амжилт.

4.6.3. Тухайн жилд нийт бүтээлүүдээс хийгдсэн иш таталтын тоо.

4.6.4. Тухайн жилд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, гүйцэтгэл.

4.6.5. Олон улсын болон бусад санхүүжүүлэгч байгууллага руу хүргүүлсэн судалгааны төсөл, хөтөлбөрийн тоо, тэдгээрийн хэрэгжилтийн үр дүн, санаачилсан байдал.

4.7. Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж нь шалгуур үзүүлэлт тус бүрт харгалзах үнэлгээг 1-5 хүртэлх оноогоор өгөх ба интервал нь хамгийн багадаа 0.5 байна.

4.8. Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж нь бүтээл болон судлаачдад үнэлгээг танилцуулж, үнэлгээг нэгтгэн, шилдэг бүтээл, шилдэг судлаачийг шалгаруулна.

Тав. Шагнал, урамшууллыг шийдвэрлэх, олгох

5.1. Эрдэм шинжилгээний нэгж нь үнэлгээний дүнг, хурлын тэмдэглэлээр баталгаажуулан төвийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулна.

5.2. Эрдэм шинжилгээний нэгжийн дүн, төвийн Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн шалгарсан шилдэг өгүүлэл, шилдэг ном тус бүрийг 1 000 000 төгрөгөөр, шилдэг судлаачийг нэг сарын үндсэн цалинтай тэнцэх төгрөгийн урамшууллыг олгоно.

5.3. Шилдэг бүтээл, шилдэг судлаачийг батламжлах, нийтэд алдаршуулах арга хэмжээг жил бүрийн Шинжлэх ухааны ажилтны өдөрт зориулсан өдөрлөгийн үеэр зохион байгуулна.

5.4. Шилдэг бүтээлийн урамшууллыг нэг бүтээлд нэг удаа олгоно.

Зургаа. Бусад

6.1. Шилдэг бүтээл, шилдэг судлаач шалгаруулах үйл ажиллагаа болон мөнгөн урамшуулалтай холбогдох зардлыг төвийн үйл ажиллагааны холбогдох зардлаас гаргана.

6.2. Сонгон шалгаруулалтад нэр дэвшигч нь (бүтээл болон судлаач) хэвлэлийн ёс зүйн хорооны дүрэм, журмаар ёс зүйн зөрчилгүй байх ба цаашид гарах ёс зүйн хариуцлагыг судлаач өөрөө бүрэн хариуцна.

ШИЛДЭГ БҮТЭЭЛ, ШИЛДЭГ СУДЛААЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД
НЭР ДЭВШҮҮЛЭХ МАЯГТ

Судлаачийн мэдээлэл:

Овог, нэр:

Харьяалах байгууллага, алба:

Утасны дугаар:

Цахим хаяг:

Сонгон шалгаруулалтад орох төрөл:

А.Шилдэг бүтээл

Б.Шилдэг өгүүлэл

В.Шилдэг судлаач

Баримт бичгийн бүрдэл тус бүр 3 хувь:

- Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл, шилдэг судлаачид дэвшүүлэх тухай албаны хурлын шийдвэр.
- Зохиогчийн эрх эзэмшигчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлэхийг дэмжсэн зөвшөөрөл.
- Судалгааны төслийн хүрээнд хэвлэн нийтлэгдсэн номын хувьд төслийн талаарх мэдээлэл.
- Номын хэвлэмэл хувь, өгүүллийн хувьд эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдсэн хувийг хэвлэж өгөх.

Эрдэм шинжилгээний шилдэг шилдэг бүтээл, шилдэг судлаачийг сонгон шалгаруулах, урамшуулах журмын дагуу холбогдох материалыг үнэн зөв бүрдүүлэн дээрх нэр бүхий бүтээлийг сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлж байна. Тус бүтээл нь зохиогчийн эрхийн зөрчилгүй болно.

Нэр дэвшүүлсэн албыг төлөөлж:

Албан тушаал:

Овог, нэр:

Гарын үсэг:

Огноо:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ ӨГҮҮЛЛИЙГ ҮНЭЛЭХ ХУУДАС

Бүтээлийн нэр:

DOI дугаар:

Зохиогч:

Өгүүллийн шалгуур үзүүлэлт	Үнэлгээ (1-5)
1. Нийтлэгдсэн шинжлэх ухааны сэтгүүлийн үзүүлэлт.	Олон улсын IF бүхий сэтгүүлд нийтлэгдсэн бол 5 оноо.
	Олон улсын IF тооцдоггүй сэтгүүлд нийтлэгдсэн бол 3 оноо.
	Үндэсний хэмжээний сэтгүүлд нийтлэгдсэн бол 3 оноо.
	Илтгэл: Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд амаар хэлэлцүүлэгдэж, хурлын бүтээл болон сэтгүүлд хэвлэгдсэн бол 3 оноо.
	Илтгэл: Үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хуралд амаар хэлэлцүүлэгдэж, хурлын бүтээл болон сэтгүүлд хэвлэгдсэн бол 2 оноо.
2. Зохиогчийн оролцоо	Нэгдүгээр зохиогч тохиолдолд 5 оноо, холбоо баригч тохиолдолд 4 оноо.
3. Өгүүллийн шинжлэх ухааны ач холбогдол	
4. Шинэлэг санаа дэвшүүлсэн байдал	
5. Судалгааны арга зүйн түвшин	
6. Тухайн өгүүллийн эшлэгдсэн тоо.	
Нийт үнэлгээ	

Огноо:

Үнэлгээ өгсөн:

Гарын үсэг:

ШИЛДЭГ НЭГ СЭДЭВТ БҮТЭЭЛИЙГ ҮНЭЛЭХ ХУУДАС

Бүтээлийн нэр:

ISBN дугаар:

Зохиогч:

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ (1-5)
1	Нэг сэдэвт бүтээлийн бичилт, зохион байгуулалт, агуулгын чанар	
2	Нэг сэдэвт бүтээлийн зоонозын өвчний шинжлэх ухааны салбарт оруулж буй хувь нэмэр, ач холбогдол	
3	Сэдвийн судлагдсан байдал	
4	Шинэлэг байдал болон ашиглагдаж буй нотолгоо, жишээний оновчтой байдал	
5	Нэг сэдэвт бүтээлийн дүгнэлт, утга санааны ойлгомжтой байдал	
6	Нэг сэдэвт бүтээлийн өгүүлбэр зүй, бичилт	
7	Нэг сэдэвт бүтээлийн үзэмж, хэвлэлийн чанар, дизайн.	
Нийт үнэлгээ		

Огноо:

Үнэлгээ өгсөн:

Гарын үсэг:

ШИЛДЭГ СУДЛААЧИЙГ ҮНЭЛЭХ ХУУДАС

Судлаачийн овог, нэр:

Харьяалах алба, Байгууллага:.....

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ (1-5)
Үндсэн шалгуур үзүүлэлт		
1	Тухайн жилд тууривсан, хянасан нэг сэдэвт бүтээлийн тоо, хэвлэсэн байдал.	
2	Тухайн жилд олон улсын хянан магадлагаа (IF) бүхий сэтгүүл, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд нийтлүүлсэн өгүүллийн тоо.	
3	Тухайн жилд олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлийн тоо, амжилт.	
4	Тухайн жилд нийт бүтээлүүдээс хийгдсэн иш таталтын тоо.	
5	Тухайн жилд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, гүйцэтгэл	
6	Олон улсын болон бусад санхүүжүүлэгч байгууллага руу хүргүүлсэн судалгааны төсөл, хөтөлбөрийн тоо, тэдгээрийн хэрэгжилтийн үр дүн, санаачилсан байдал.	
Нэмэлт шалгуур үзүүлэлт		
7	Зоонозын өвчний чиглэлээр тухайн жилд судалгаа гүйцэтгэж, үр дүнгээр нь олон улсын хэмжээнд өгүүлэл нийтлүүлсэн, нэг сэдэвт бүтээл орчуулж, танилцуулсан байдал.	Орчуулсан материал, бүтээлтэй тохиолдолд 1 оноо.
8	Шинээр хамгаалсан магистр, докторын судалгааны ажилд зөвлөх, удирдагчаар ажилласан байдал.	Байгаа тохиолдолд 1 оноо.
9	Тухайн жилд мэргэжлийн сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлэл, судалгааны материалыг хянасан, шүүмж өгсөн байдал.	Байгаа тохиолдолд 1 оноо.
Нийт үнэлгээ		

Огноо:

Үнэлгээ өгсөн:

Гарын үсэг: